



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/128

Номгон

Инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах
газрын нэр, байршил батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бууцагаан, Бөмбөгөр, Хүрээмарал, Эрдэнэцогт, Жинст сумдад шинээр худаг, уст цэг гаргах газрын байршил, нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Инженерийн хийцтэй уст цэг гаргах ажлыг чанартай гүйцэтгэхийг шалгарсан “Чорьж Бүрд” ХХК (Ж.Сангизав), ашиглалт, эзэмшилт, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын *О.Т.* оны *08* дугаар
сарын *07*-ны өдрийн *7/128* дугаар
захирамжийн хэвсрэлт



ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ УСТ ЦЭГ ШИНЭЭР
ГАРГАХ СУМЫН НЭР, БАЙРШИЛ

Д/д	Сумын нэр	Багийн нэр	Газрын нэр
1	Бууцагаан	5 дугаар баг	Нурамт нугалаа
2	Бөмбөгөр	1 дүгээр баг	Дунд нуруу
3	Хүрээмарал	2 дугаар баг	Нарийн суурийн улаан толгой
4	Эрдэнэцогт	4 дүгээр баг	Цахилдаг түрүү
5	Жинст	3 дугаар баг	Хөнөг

.....оОо.....